



Төлөвлөгөө баталсан:

Төсвийн Төвлөрүүлэн захирагч

НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА

.....
(гарын үсэг)

Б.БАТЖАРГАЛ

Тэмдэг

.....
(огноо)

Төлөвлөгөөг боловсруулсан:

Төсвийн шууд захирагч

ЗАВХАН АЙМГИЙН НИЙГМИЙН
ДААТГАЛЫН ГАЗРЫН ДАРГА

.....
(гарын үсэг)

С.НЯМЖАВ

.....
(огноо)

ЗАВХАН АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэт гэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт.							
Зорилт 1: “Нийгмийн даатгалын хууль тогтоомж, нийгмийн даатгалын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын дунд хугацааны төсвийн төсөл, төсөөлөл болон төсвийн нарийвчилсан хуваарийн санал боловсруулах, гүйцэтгэлд хяналт тавих, судалгаа хийх, ирээдүйн төлөв байдал, урт хугацааны урьдчилсан (актуар) тооцоолол хийх, үнэлэлт дүгнэлт өгөх, санал боловсруулах, нийгмийн хамгааллын чиглэлээр байгуулсан олон улсын хэлэлцээрийн хэрэгжилтийг зохион байгуулах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:							
1.1	Нийгмийн даатгалын багц хууль /шинэчилсэн найруулга/ болон Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой шинээр батлагдсан дүрэм, журам, дээд газраас ирүүлсэн заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг зохион байгуулах	-	Хэрэгжүүлсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн тоо	Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой НДЕГ-аас 2024 онд ирүүлсэн 15 чиглэл, 14 зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан.	Дээд газраас ирүүлсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж, үр дүнг тооцож ажилласан байна.	НДЕГ–аас ирүүлсэн 159 албан бичиг бичгээс НДЕГ-ын тушаал 23, хууль хэрэгжүүлэх зөвлөмж 6, чиглэл 8, албан даалгавар 1 ирүүлсэнийг нийт байцаагч ажилтнуудад хүргүүлэн арга зүйн зөвлөмжөөр ханган ажиллаж байна. Хугацаатай 39 албан бичгийг хугацаанд нь шийдвэрлэн хариуг холбогдох байгууллагад хүргүүлсэн. Сумдын байцаагчдад хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах 27 удаагийн зөвлөмжийг хүргүүлэн ажилласан.	100
1.2	Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын төсвийн нарийвчилсан хуваарь, сар, улирлын хуваарийг мөрдөх	Тухайн аймаг, дүүргийн орлого, зарлагын төсөв	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаалаар баталсан хуваарийн дагуу төсвийг зарцуулсан байна.	Нийгмийн даатгалын санд 2024 онд 45027.4 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардалд 119047.8 сая төгрөг зарцуулсан.	Батлагдсан төсвийн хуваарь, дээд газраас ирүүлсэн зөвлөмж, чиглэлийг мөрдөж ажилласан байна.	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын төсвийн нарийвчилсан хуваарь, сар, улирлын хуваарийг мөрдөн ажиллаж байна.	100

1.3	Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны урсгал зардлын төсвийн нарийвчилсан хуваарь, сар, улирлын хуваарийг мөрдөж ажиллах	Тухайн аймаг, дүүргийн ҮА-ны зардлын төсөв	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаалаар баталсан хуваарийн дагуу төсвийг зарцуулсан байна.	Нийгмийн даатгалын байгууллагын 2024 оны үйл ажиллагааны урсгал зардалд 2060.4 сая төгрөг зарцуулж, 89.8 сая төгрөгний нэмнэлттэй ажилласан.	Батлагдсан төсвийн хуваарь, дээд газраас ирүүлсэн зөвлөмж, чиглэлийг мөрдөж ажилласан байна.	Байгууллагын үйл ажиллагааны урсгал зардлын төлөвлөгөө 1120208.3 мянган төгрөгийг батлагдсанаас 1042614.9 мянган төгрөгийн зардлыг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулж 77593.4 мянган төгрөгийг хэмнэж ажилласан.	100
1.4	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагааг хэрэгжүүлэх ажлын биелэлтийг хангах	-	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний тоогоор	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх 1 арга хэмжээ зохион байгуулсан.	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангасан байна.	“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян-2025” арга хэмжээнд оролцож “Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх хуулийн сургалт”-ыг зохион байгуулан ажилласан. Мөн “Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль”-аар live хийн иргэд даатгуулагчдад мэдээлэл хийсэн. Аймгийн Прокурорын газрын албан хаагчдад дээрх хуулиар сургалт сурталчилгаа зохион байгуулсан.	100
1.5	Ажил олгогч, иргэд, даатгуулагчаас сэтгэл ханамжийн судалгаа авах ажлыг зохион байгуулж, үр дүнг хагас жил тутам Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлэх	-	2 удаагийн сэтгэл ханамжийн судалгаа хийгдсэн байна.	-	Ажил олгогч, иргэд, даатгуулагчийн сэтгэл ханамжийг 1-5 оноогоор дүгнэж, судалгааны үр дүнг албан бичгээр 6 дугаар сарын 10, 12 сарын 10-ны өдрийн дотор Нийгмийн даатгалын ерөнхий газар хүргүүлсэн байна.	Нэг цэгийн үйлчилгээний байцаагчдын үйлчилгээний харилцаа хандлага, чанар хүртээмжийг үнэлэх зорилгоор QR код байршуулсан. Ажилтан албан хаагчдын харилцаа хандлагатай холбоотой гомдол санал ирээгүй байна.	90

Хоёр. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт

Зорилт 2: “Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэх, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлын санхүүжилт, шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлтийг хуулиар тогтоосон хугацаанд олгох, өр барагдуулах ажлыг удирдан зохион байгуулах, өмчийн харилцаа, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг зохион байгуулах, мөнгөжүүлсэн орлогыг тэтгэврийн нөөц санд байршуулах, нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулж, сангийн хөрөнгийг нэмэгдүүлэх, нягтлан бодох бүртгэлийн мэргэжил арга зүйгээр хангах, гүйцэтгэлийг тайлагнах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:

2.1	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны А/183 тоот тушаалаар батлагдсан “Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг төвлөрүүлэх, хуваарилах, санхүүжилт олгох, хяналт тавих журам”-ын 3.3 дах заалтыг хэрэгжүүлж ажиллах.	-	НДЕГ-ын төвлөрсөн орлогын харилцах дансанд өдөр бүр бүрэн төвлөрүүлнэ.	Нийгмийн даатгалын төвлөрсөн сангийн харилцах дансны орлого 49267.9 сая төгрөгийг өдөр бүр төвлөрүүлсэн.	НДЕГ-ын төвлөрсөн орлогын харилцах дансанд өдөр бүр бүрэн төвлөрүүлсэн байна.	НДЕГ-ын төвлөрсөн харилцах дансанд хагас жилийн байдлаар нийт 29268956.7 мянган төгрөгийг бүрэн төвлөрүүлсэн.	100
2.2	Нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулах.	-	Хууль тогтоомжийн дагуу иргэд даатгуулагчдад тэтгэвэр тэтгэмж төлбөр зардлыг хугацаанд нь олгоно.	Нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулсан.	а) Тэтгэврийг сар бүрийн 01-ний өдөр олгох б) Нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төсвийн дагуу хуульд заасан хугацаанд зарцуулсан байна. в) Төсвийн хуваарийн өөрчлөлтийг хуулийн хугацаанд өөрчлөлт оруулсан байна г) Нийгмийн даатгалын сан хариуцах шимтгэлийг гүйцэтгэлээр бүрэн шилжүүлсэн байна.	1.Тэтгэврийг арилжааны банкуудтай хамтран сар бүрийн 01-ний өдөр олгож байна. Банкуудтай тохирсон өдрүүдэд жагсаалтаар тэтгэврийг олгож байна. 2.Зардлын төлөвлөгөө 68661725.3 мянган төгрөг, 66395888.4 мянган төгрөгийг тэтгэвэр тэтгэмжид олгож 96.7 хувийн гүйцэтгэлтэй байсан. 3.Батлагдсан ажилгүйдлийн зардлын төсөв хүрэлцэхгүй байгаа тул 2025 оны 04 дүгээр сард тооцоолол хийж Бодлого хэрэгжилт, төлөвлөлтийн газарт албан тоот хүргүүлж төсвийн хуваарьт өөрчлөлт орсноор ажилгүйдлийн тэтгэмжийг тухай бүрт нь олгож байна. 4.Нийгмийн даатгалын сангаас 0-3 насны эхчүүдийн 47819.9 мянган төгрөгний шимтгэлийг бүрэн шилжүүлж ажилласан.	100

2.3	Батлагдсан зардлын төсөв, хөрөнгө оруулалтын зардлын үр ашгийг дээшлүүлж, хэмнэлтийн зарчмыг баримтлах.	-	Батлагдсан төсвийг зардлын эдийн засгийн ангилал хооронд шилжүүлэн зарцуулахгүй, ажиллагсадтай холбоотой болон бусад өр авлагагүй ажиллана.	Батлагдсан төсвийг зардлын ангиллын дагуу зарцуулсан.	а)Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх. б)Батлагдсан төсвийг зардлын ангиллын дагуу зарцуулах в) Ажиллагсадтай холбоотой цалин, шимтгэл, татвар болон бусад өр авлага үүсгээгүй байна.	а.Төсвийн хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлснээр бараа үйлчилгээний бусад зардлаас 77593.4 мянган төгрөгийн зардал хэмнэсэн. б.Байгууллагын үйл ажиллагааны урсгал зардлын төлөвлөгөө 1120208.3 мянган төгрөгийг батлагдсанаас 1042614.9 мянган төгрөгийн зардлыг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулж, 77593.4 мянган төгрөгийг хэмнэж ажилласан. в.Албан хаагчидтай холбоотой цалин, шимтгэл, татварын өр үүсгээгүй байна.	100
2.4	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын сангийн болон байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөх, төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, санхүүгийн тайлан гаргах ажлыг зохион байгуулах	-	Санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайланг үнэн зөв гаргаж, тогтоосон хугацаанд хүргүүлнэ.	Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, сангийн орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, байгууллагын төсвийн гүйцэтгэлийн зарлагын мэдээ, сангийн орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг гаргаж, ирүүлсэн.	Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлийн тайлан, байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, сангийн орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, байгууллагын төсвийн гүйцэтгэлийн зарлагын мэдээ, сангийн орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг үнэн зөв гаргаж, хугацаанд нь хүргүүлсэн байна.	Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ, Нийгмийн даатгалын төсвийн гүйцэтгэлийн зарлагын сарын мэдээ, Нийгмийн даатгалын сангийн өр авлага, хамралтын сарын мэдээг тус тус 6 удаа хугацаанд нь хүргүүлсэн. Төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ, сангийн санхүүгийн тайланг 2 удаа хугацаанд нь үнэн зөв гарган НДЕГ азарт тайлагнасан.	100

2.5	Байгууллагын хэвийн үйл ажиллагаанд шаардагдах өмч хөрөнгийн хэрэгцээ, захиран зарцуулалт, хадгалалт хамгаалалтыг төлөвлөх, хэрэгжүүлэх, ил тод тайлагнах.	-	Байгууллагын хэвийн үйл ажиллагаанд шаардагдах өмч хөрөнгийг захиран зарцуулалт, хадгалалт хамгаалалтыг төлөвлөн хэрэгжүүлж, тайлагнаж ажиллана.	Байгууллагын хэвийн үйл ажиллагаанд шаардагдах өмч хөрөнгийн хэрэгцээ, захиран зарцуулалт, хадгалалт хамгаалалтыг төлөвлөн хэрэгжүүлж, тайлагнасан байна.	Үндсэн хөрөнгө актлах, шилжүүлэх үйл ажиллагааг хууль дүрэм, журамд нийцүүлэн өмч хамгаалах байнгын зөвлөлийн дүгнэлт, холбогдох баримтыг үндэслэн хөрөнгийн нэмэгдэх, хасагдах хөдлөлийг цаг тухай бүрд нь бүртгэлд тусгах; Эзэмшил газар, барилга байгууламж, тээврийн хэрэгсэл, үндсэн хөрөнгө г.м/ нэгдсэн судалгааны маягтууд ТӨХ/ТӨХ-1-с ТӨХ-11 маягт/ болон мэргэжлийн байгууллагад гаргаж өгдөг мэдээ тайланг хуулийн хугацаанд мэдээлэх; Хагас болон бүтэн жилийн тооллогоор үнэ тогтоолгох, шилжүүлэх, актлах, хөрөнгийн жагсаалтыг тогтоосон хугацаанд хүргүүлэх; Өмч хамгаалах байнгын зөвлөл журмын дагуу ажиллуулах;	НДЕГ-ын даргын 2025 оны А/08 дугаар тушаал “Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгах, үнийг шинэчлэн тогтоох, шилжүүлэх тухай” Хөрөнгийн хөдлөлийг 2024 оны 12 сарын 31 өдрөөр НББ, санхүүгийн тайланд тусгаж, биелэлтийг 2025 оны 1-р улиралд багтаан ТӨБЗГ, Санхүү бүртгэл, хөрөнгө оруулалтын газарт тус тус хүргүүлсэн. Газрын үндсэн хөрөнгийн мэдээллийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын www.pcsp.gov.mn цахим хуудасны burtgel.pcsp.gov.mn холбоосонд байршуулсан “Төрийн болон орон нутгийн өмчийн тооллогын систем”-ийн программ хангамжид 2024 оны үндсэн хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтийн тайланг бүрэн оруулан ажилласан.	100
-----	--	---	--	---	--	---	-----

					Хөрөнгийн ашиглалт хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж, үндсэн хөрөнгө, маягтын тооллого хийх ажлыг зохион байгуулж, дүнг хугацаанд нь хүргүүлэх; Үндсэн хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтийн тайланг “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем” программд дараа оны 3 дугаар сарын 5-ны дотор оруулах; -Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээ, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг бүрэн хангах, Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээний орлогыг санд бүрэн төвлөрүүлсэн байна.	-ТӨХ1-ээс ТӨХ11 маягтыг гарган СБГазарт хүргүүлсэн. -Өмч хамгаалах зөвлөл журмын дагуу 1 удаа хуралдсан бөгөөд Элэгдлээрээ өртөгөө нөхөж, үлдэх өртөггүй болсон 10 нэр төрлийн 10ш 4795.9 мянган төгрөгийн хөрөнгийг 1 жил хугацаагаар сунгах, 41 нэр төрлийн 82ш 16700.3 мян төгрөгийн хөрөнгийг актлуулахаар хэлтсийн “Өмч хамгаалах байнгын зөвлөл”-д хүргүүлэн дүгнэлт гаргуулж Нийгмийн даатгалын ерөнхий газрын санхүү бүртгэл, хөрөнгө оруулалтын газарт Газрын даргын 2025 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 199 тоотойр хүргүүлэн ажилласан.	
--	--	--	--	--	--	--	--

2.6	Төсвийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулж, Аудитын байгууллагаас “Өөрчлөлтгүй” дүгнэлттэй ажиллах.	-	Өөрчлөлтгүй дүгнэлт авах, зөвлөмж, акт, албан шаардлагыг хугацаанд нь бүрэн биелүүлнэ.	а) Нийгмийн даатгалын байгууллагын болон сангийн санхүүгийн тайлангийн Аудитын шалгалтаар өөрчлөлтгүй дүгнэлт авсан. б) Санхүүгийн тайлангийн аудитын тайлангаар өгсөн залруулга, зөвлөмж, акт, албан шаардлагыг хэрэгжүүлсэн байна.	а) Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлангийн Аудитын шалгалтаар “Өөрчлөлтгүй” дүгнэлт авах. б) Санхүүгийн тайлангийн аудитын тайлангаар өгсөн залруулга, зөвлөмж, акт, албан шаардлагыг 100.0 хувь биелүүлсэн байна.	а.Нийгмийн даатгалын газрын 2024 оны жилийн төсвийн гүйцэтгэлийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд баталгаажуулах аудит хийлгэж “Өөрчлөлтгүй” дүгнэлт авсан. б.Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудитын тайлангаар 145759.8 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн. Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд тайлант хугацаанд зөрчил давтан гаргаагүй байна. Зөвлөмжийн төлөвлөгөө, биелэлтийг https://fas.audit.mn/-д хугацаанд оруулан тайлагнасан.	100
2.7	Банкуудтай байгуулсан ерөнхий гэрээг хэрэгжүүлэх, дүгнэх, биелэлтийг Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлэх.	-	Нийгмийн даатгалын ерөнхий газраас арилжааны банкуудтай байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-г хэрэгжүүлэн, хэрэгжилтийг дүгнэн Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлнэ.	Банкуудтай байгуулсан ерөнхий гэрээний хэрэгжилтийг хангаж ажилласан.	а) Банкуудтай байгуулсан ерөнхий гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллах. б) Гэрээний хэрэгжилтийг дүгнэж, дүнг Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлсэн байна.	Арилжааны банкттай байгуулсан гэрээнд өдөр бүрийн үлдэгдэлд хүү тооцон 41713.6 мянган төгрөгийг хүүгээр бүртгэсэн. Тэтгэвэр тавьж олгосны үйлчилгээний хураамж 2626.5 мянган төгрөг шилжүүлсэн.	100

2.8	Нийгмийн даатгалын сангийн цахим мэдээллийн санг тухай бүр үнэн зөв бүрдүүлэх.	-	Холбогдох хууль тогтоомжийн дагуу мэдээллийг үнэн зөв оруулж бүртгэнэ.	Нийгмийн даатгалын сангийн мэдээллийн баазыг тогтоосон хугацаанд хаалт хийлгэсэн.	а) Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг цаг хугацаанд нь үнэн зөв бүртгэх ажлыг зохион байгуулж, бүртгэлийн алдаа, залруулга гаргахгүй байх. б) Ажил олгогч, даатгуулагчийн мэдээллийг үнэн зөв бүртгэж мэдээллийн сан бүрдүүлсэн байна.	а.Өдөр бүр арилжааны банкны төвлөрсөн сан, төрийн сангийн хуулгийг бүрэн боловсруулж үнэн зөв бүртгэж байна. Нэр, регистрийн дугаар, утасны дугаар нь тодорхойгүй байгаа 16 даатгуулагчийг арилжааны банкттайгаа хамтран ажиллаж УОО бүрэн таниулсан. б.Нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн системийн НББ дэд системд аж ахуйн нэгж, байгууллага болон сайн дурын даатгуулагчийн төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийг, ажил олгогч, даатгуулагчаар таниулан бүртгэж байна. Олгосон тэтгэвэр, тэтгэмжийг төрлөөр, банкаар бүртгэж өглөгөө хааж байна.	100
2.9	Нийгмийн даатгалын мэдээллийн систем хөгжүүлэх” төслийн хүрээнд Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийн шинэчлэлтэй холбоотой ажлыг хэрэгжүүлэх.	-	ХНХЯ-тай гэрээтэй Ай Ти Зон ХХК-ийн Төслийн багтай хамтран Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийг “Core” системээр хөтлөх ажлыг хийж гүйцэтгэнэ.	ХНХЯ-тай гэрээтэй Ай Ти Зон ХХК-ийн Төслийн багаас зохион байгуулсан ажлуудад оролцсон.	Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийг “Core” системээр хөтлөх ажлын гүйцэтгэлийг хангаж ажилласан байна.	НББ дэд системд банкны хуулга татах, орлого таниулах, бусад өглөг авлагыг бүртгэж хаах ажлыг хийж гүйцэтгэж байна. Тэтгэвэр, тэтгэмж авч байгаа даатгуулагчийн өглөг хаалтыг бүрэн хийж байна.	100

2.10	Нягтлан бодох бүртгэлийн тооцооны өглөг, авлагыг тооцоо нийлсэн актаар шинэчлэн баталгаажуулах	-	Нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомжийг хэрэгжүүлж, тооцоо нийлсэн актаар баталгаажуулна.	Тооцооны үлдэгдлийг баталгаажуулсан.	а) Нийгмийн даатгалын байгууллагын санхүүгийн тайлангийн тооцооны үлдэгдлийг эзэн холбогдогч бүрээр бүрэн шинэчлэн баталгаажуулах. б) Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлангийн тооцооны үлдэгдлийг эзэн холбогдогч бүрээр бүрэн шинэчлэн баталгаажуулсан байна.	а.Нийгмийн даатгалын байгууллагын 2025 оны хагас жилийн санхүүгийн тайлангийн тооцооны үлдэгдлийг бүрэн баталгаажуулан, өглөг авлага үүсээгүй байна. б.Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлангийн тооцооны үлдэгдлийг эзэн холбогдогч бүрээр шинэчлэн, сумдын байцаагчид болон газрын хариуцсан байцаагчидтай тооцоо нийлж баталгаажуулан ажилласан.	100
Зорилт 2.1: “Нийгмийн даатгалын хууль тогтоомжид заасны дагуу шимтгэлийн орлогыг төвлөрүүлэх, сан бүрдүүлэх, ажил олгогч, даатгуулагч, сайн дураар даатгуулагчдыг нийгмийн даатгалд хамруулах, шимтгэлийн өр барагдуулах ажлыг зохион байгуулах ажлыг зохион байгуулах, аж ахуйн нэгж, байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах, нийгмийн даатгалын байгууллагуудыг мэргэжил, арга зүгээр хангах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:							
2.1.1	Сайн дурын даатгалын хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор малчид болон албан бус хөдөлмөр эрхлэгч иргэдийг сайн дурын даатгалд шинээр хамруулах төлөвлөгөө баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;	Шаардлагагүй	Сайн дурын даатгалд шинээр хамруулсан даатгуулагч (малчин)-ийн тоо, өсөлтийн хувь, төлөвлөгөөний биелэлтийн хувь	2024 онд шинээр 1261 хүнийг сайн дурын даатгалд, үүнээс 848 малчин хамруулав.	Сайн дурын даатгалд шинээр 793 хүнийг үүнээс 541 малчин шинээр хамруулж төлөвлөгөөг биелүүлсэн байна.	2025 оны эхний хагас жилийн байдлаар сайн дурын даатгалд шинээр 608 хүнийг хамруулж төлөвлөгөөг 153 хувиар, үүнээс 408 малчин шинээр хамруулж төлөвлөгөөг 150 хувиар биелүүлсэн байна.	100

2.1.2	Албан журмын даатгалын хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор нийгмийн даатгалд хамрагдаагүй ажил олгогч, даатгуулагчдыг шинээр хамруулах төлөвлөгөө баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;	Шаард-лагагүй	Албан журмын даатгалд шинээр хамрагдсан ажил олгогч, албан журмын даатгуулагчийн тоо, өсөлтийн хувь, төлөвлөгөөний биелэлтийн хувь	2024 онд 83 ажил олгогч, 808 хүнийг албан журмын даатгалд хамруулав.	Ажил олгогчийн тоог шинээр 42, даатгуулагчийн тоог шинээр 252 хүнээр нэмэгдүүлж, төлөвлөгөөг биелүүлсэн байна.	Шинээр 39 ажил олгогч, 93 даатгуулагч хамруулсан. Албан журмын даатгалд шинээр хамрагдаж байгаа ихэнх ажил олгогчийн даатгуулагчийн тоо 1-2 байгаа учир шинээр хамруулах даатгуулагчийн тоо биелэхгүй байна.	100
2.1.3	Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн авлагыг оны эхний үлдэгдэлээс 30 доошгүй хувиар бууруулах;	-	Хуримтлагдсан авлагыг тухайн санхүүгийн жилд бүрэн барагдуулсан байх	Нийгмийн даатгалын шимтгэлийн авлагын хэмжээ 2024 оны жилийн эцэст 816200.9 мян.төгрөгт хүрсэн.	Нийгмийн даатгалын шимтгэлийн авлагын хэмжээ 816200.9 мян.төгрөгийг /2.1.4-д зааснаас бусад шимтгэлийн авлага/ бүрэн барагдуулах. Шинээр нэмж өр үүсгэхгүй байх талаар анхаарч ажиллах.	Оны эхний Нийгмийн даатгалын шимтгэлийн авлагын 816200.9 мянган төгрөгийн үлдэгдэлээс 624871.5 мянган төгрөгийг барагдуулж, хуримтлагдсан өр авлагын барагдуулалт 76.5 хувьтай байна. Шимтгэлийн авлагын оны эхний үлдэгдэлийг 30 хувь барагдуулалт зорилтын хувьд 2.5 дахин их биелүүлсэн байна.	100

2.1.4	Төсөвт байгууллага болон орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын шимтгэлийн өрийг бүрэн барагдуулсан байх;	-	Шимтгэлийн өргүй гарсан байх.	Төсөвт байгууллагын шимтгэлийн өр 138111.3 мян.төгрөг, орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын шимтгэлийн өр 678089.6 мян.төгрөг байна.	Төсөвт байгууллага болон орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын шимтгэлийн өрийг бүрэн барагдуулж шинээр нэмж өр үүсгэхгүй байх талаар анхаарч ажиллах.	Төсөвт байгууллагын 136769.8 мянган төгрөгийн шимтгэлийн өрийг барагдуулж, барагдуулалт 99 хувь, Орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын 490251 мянган төгрөгийн шимтгэлийн өрийг барагдуулж, барагдуулалт 72.3 хувьтай байна. 1 төсөвт байгууллагын 134.5 мянган төгрөг, 4 ажил олгогчийн 3960.1 мянган төгрөгийн найдваргүй барагдах авлага байна. Үүнд: 1.Яруумандал ХХК, Сонгинохайрхан уул ХХК нарын эзэн холбогдогч нас барсан. 2.Завхан аймгийн жижиг дунд үйлдвэрийг дэмжих төв татагдан буугдаж эзэн холбогдогч тогтоох боломжгүй байна. 3.Улиастай мэд түүхий эд бэлтгэл тооцооллын алдаанаас болж үүссэн өр авлага байна. 4.Шинэ дөрвөлжин ОНӨҮГ татан буугдсан. Эзэн холбогдогчийг тогтоохоор холбогдох баримт, материалыг бүрдүүлэн ажиллаж байна.	85.7
2.1.5	Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн дагуу нийгмийн даатгалын сангийн орлогыг бүрдүүлэх ажил зохион байгуулах;	-	Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн тухай хуулийн дагуу орлогын гүйцэтгэл 100 % хангуулна.	Нийгмийн даатгалын санд 45.0 тэрбум төгрөгийн орлого хуримтлуулав.	Нийгмийн даатгалын санд 54.7 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлнэ.	Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг сар, улирал, жилээр жигд ханган биелүүлж, нийгмийн даатгалын сангийн орлогыг 25310909.6 мянган төгрөгөөр буюу 100.2 хувиар биелүүлсэн. Зардлын төлөвлөгөө 68661725.3 мянган төгрөг, 66395888.4 мянган төгрөгийг тэтгэвэр тэтгэмжид олгож 96.7 хувийн гүйцэтгэлтэй байна.	100

Гурав. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт

Зорилт 3: “Нийгмийн даатгалын бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, сангийн болон үйл ажиллагааны зардлын зарцуулалтад аудит хийх, дүгнэлт зөвлөмж гаргах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:

3.1	Байгууллагын нээлттэй мэдээллийн ил тод байдлын хэрэгжилтийг хангаж, байгууллагын цахим хуудаст болон мэдээллийн самбарт хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж, хяналт тавих;	-	Мэдээлэл байршуулалтыг 100 хувьд хүргэнэ.	Байгууллагын цахим хуудсанд мэдээлэл байршуулалт 2024 оны жилийн эцсийн байдлаар 100 хувийн гүйцэтгэлтэй байна.	Байгууллагын мэдээллийг үнэн зөв, бодитой мэдээлж мэдээллийн ил тод, нээлттэй байдал хангагдан иргэдийн мэдээлэл авах эрхийг хангаж ажилласан байна.	Газрын даргын 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн А/20 дугаартай тушаалаар мэдээлэл байршуулах болон хяналт тавих эрх бүхий албан тушаалтныг томилсон. 2025 оны эхний хагас жилийн байгууллагын нээлттэй мэдээллийн ил тод байдлыг “shilen.gov.mn”-д хуульд заасан хугацаанд байршуулсан.	100
3.2	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, шилэн дансны цахим хуудаст Нийгмийн даатгалын сан, байгууллагын санхүү үйл ажиллагааны мэдээллийг хугацаанд үнэн зөв, бодитой бүрэн мэдээлж, мэдээлэл байршуултад хяналт тавих;	-	Сар бүрийн хугацаанд байршуулсан мэдээлэл 100 хувь байна. Шилэн дансны хөтлөлтийн тайлан /4/-г байгууллагын цахим хуудаст Улирал бүрийн дараа сарын 15-ны өдрийн дотор мэдээлсэн байна.	Шилэн дансны хөтлөлтийн 2024 оны нэгдсэн тайлангаар мэдээлэл байршуулалт 100 хувьтай байна.	Нийгмийн даатгалын байгууллагын санхүү үйл ажиллагаа болон сангийн мэдээллийг хуулийн хугацаанд нь үнэн зөв мэдээлж, иргэдийн мэдээлэл авах эрхийг хангаж ажилласан байна.	2025 оны эхний хагас жилийн байдлаар шилэн дансны цахим хуудсанд “Шилэн дансны хууль” болон “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын дагуу тайлант хугацаанд тусгай зориулалтын сангийн мэдээллийг 68 удаа мэдээлэхээс хугацаандаа 68, газрын үйл ажиллагааны зарцуулалтын мэдээллийг 73 удаа мэдээлэхээс хугацаандаа мэдээлсэн 73 байна. Хугацаа хоцорсон мэдээлэл байхгүй ба бүрэн мэдээлсэн.	100

Зорилт 3.1: “Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг ажил олгогч, даатгуулагч, иргэн болон нийгмийн даатгалын орон нутгийн нэгжид хяналт шалгалт хийж шийдвэр гаргах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх, үр дүнг сайжруулах чиглэлээр санал боловсруулах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:

3.1.1	Нийгмийн даатгалын багц хуулийн хэрэгжилтийг газрын даргын баталсан удирдамжийн дагуу аж ахуйн нэгж, байгууллагад болон газрын үйл ажиллагаа, сангийн зарцуулалтад хяналт шалгалт хийж илэрсэн төлбөр, зөрчлийн 70-аас доошгүй хувийг барагдуулж ажиллах,	-	Шалгасан аж ахуйн нэгж, байгууллагын тоо, хамрагдалтын хувь, Шалгалтад хамрагдсан нийгмийн даатгалын сангийн тоо, мэдээлэл, Илэрсэн төлбөр, зөрчлийн барагдуулалтын хувь.	-	Шалгалтын үр дүнг тухай бүрт тооцон газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж холбогдох шийдвэр гарган, актын барагдуулалтын мэдээ, тайланг Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газарт хүргүүлж ажилласан байна.	Тус газарт бүртгэлтэй ажил олгогчийн 30 хувийг хамруулан шалгахад удирдамжийг батлуулсан. Удирдамжийн дагуу шалгалтыг хийж гүйцэтгэж байгаа бөгөөд шалгалтын хугацаа 2025 оны 08 дугаар сарын 01-ний өдөр хүртэл явагдана. 2025 оны эхний хагас жилийн байдлаар 7 ажил олгогчийн 11 даатгуулагчтай холбоотой хугацаандаа төлөгдөөгүй 3,408.5 мянган төгрөгийн шимтгэл болон түүнд ногдох алдангийг “Зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авахаас татгалзсан материал” хүлээн авч шийдвэрийг Прокурорын байгууллагаар хянуулан хугацаандаа төлөгдөөгүй шимтгэлийг нөхөн төлүүлсэн. “Зөрчлийн тухай хууль”-ийн 10 дугаар зүйлийн 10.17.4 дэхь заалтын дагуу 4 ажил олгогчид 1,000.0 мянган төгрөгийн торгууль ногдуулан хялбаршуулсан журмаар шийдвэрлэн төлбөрийг бүрэн барагдуулсан. Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилт ханган ажиллаж байна. Аймгийн прокурорт сар бүр мэдээгээ гарган хүргүүлсэн. Нийт 18 ажил олгогчийг шалгаж 22 даатгуулагчтай холбоотой 3,796.5 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг дутуу төлсөн зөрчил илэрч Улсын байцаагчийн акт тогтоон 3,796.5 мянган төгрөгийг барагдуулан актын биелэлт 100 хувьтай байна.	100
-------	---	---	---	---	--	--	-----

3.1.2	Их, дээд, коллеж болон ерөнхий боловсролын дунд сургуулийн үйл ажиллагаа эрхэлдэг хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд Нийгмийн даатгалын багц хууль, тогтоомжийн хэрэгжилтийг шалгах ажлыг зохион байгуулан үр дүнг тооцож ажиллах;	-	Их, дээд, коллеж болон ерөнхий боловсролын дунд сургуулийн үйл ажиллагаа эрхэлдэг хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагууд ыг шалгасан байна.	-	Нийгмийн даатгалын ерөнхий газраас ирүүлсэн жагсаалтад тусгагдсан нэр бүхий аж ахуйн нэгж, байгууллагад нийгмийн даатгалын багц хууль, тогтоомжийн хэрэгжилтийг шалгаж, илэрсэн зөрчлийг арилгах, хуулийн дагуу шийдвэрлэх, хариуцлага тооцох, мэргэжил арга зүйн зөвлөгөө, зөвлөмж өгч ажилласан байна.	Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа гурван их дээд сургууль, коллеж байгаа бөгөөд 2 ажил олгогчийн 2020-2024 оны санхүүгийн баримтыг бүрэн шалгаж дууссан. Шалгалтаар Хөгжим бүжгийн коллеж нь 2024 онд 4 даатгуулагчтай холбоотой хүүхдээ асрах чөлөөтэй байгаа хугацааны нийгмийн даатгалын шимтгэлийг тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний хэмжээнээс ажил олгогчийн төлөх хувь хэмжээгээр тайлагнаагүй орхигдуулсан зөрчил илэрсэн. Гомдол мэдээллийг хүлээн авахаас татгалзах хэрэг үүсгэн прокурорын байгууллагаар хянуулахаар хүргүүлэн ажилласан. Мөн тус ажил олгогч нь 9 даатгуулагчтай холбоотой төрлийн кодыг буруу тайлагнасан ба шалгалтын явцад холбогдох журамд заасны дагуу залруулах арга хэмжээ авч ажилласан. НДЕГ-ын Дотоод аудит мониторингийн газрын даргын 2025.05.21-ны өдрийн 02/1270 тоот албан бичгийн дагуу хийгдэж буй хяналт шалгалтын ажлыг 10 дугаар сард шалгаж дуусгахаар түр зогсоосон.	100
-------	---	---	---	---	--	---	-----

3.1.3	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг хувийн хэвшлийн ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд Нийгмийн даатгалын багц хууль, тогтоомжийн хэрэгжилтийг шалгах ажлыг зохион байгуулан үр дүнг тооцож ажиллах;	-	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлдэг хувийн хэвшлийн ахуйн нэгж, байгууллагууд ыг шалгасан байна.	-	Нийгмийн даатгалын ерөнхий газраас ирүүлсэн жагсаалтад тусгагдсан нэр бүхий аж ахуйн нэгж, байгууллагад нийгмийн даатгалын багц хууль, тогтоомжийн хэрэгжилтийг шалгаж, илэрсэн зөрчлийг арилгах, хуулийн дагуу шийдвэрлэх, хариуцлага тооцох, мэргэжил арга зүйн зөвлөгөө, зөвлөмж өгч ажилласан байна.	Тайлант оны III-IV улиралд шалгагдахаар тус газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан болно.	...
3.1.4	Ажилгүйдлийн даатгалын сангийн 2022-2024 оны орлого бүрдүүлэлт, зарцуулалтад гүйцэтгэлийн хяналт шалгалт хийж үр дүнг тооцох, тайланг заасан хугацаанд Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газарт хүргүүлэх;	Батлагдсан төсвийн хүрээнд	Шалгалт хийсэн объектын гүйцэтгэлийн хувь Илрүүлсэн зөрчлийн 70-аас доошгүй хувийг барагдуулах, Шалгалтын тайланг хугацаанд Хяналт шалгалтын газарт хүргүүлсэн байна.	-	Ажилгүйдлийн даатгалын сангийн бүрдүүлэлт, зарцуулалтыг шалгаж, үр дүнг тооцож, илэрсэн зөрчлийн 70-аас доошгүй хувийг барагдуулж ажилласан байна.	Тус газрын ажилгүйдлийн даатгалын сангийн 2022-2024 оны орлогын бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт шалгалтыг гүйцэтгэн хугацаанд нь биелэлтийг хүргүүлэн ажилласан. Шалгалтаар 54 даатгуулагчтай холбоотой зөрчил илэрснээс ажилгүйдлийн тэтгэмжийг 26 даатгуулагчид 19,531.3 мянган төгрөг илүү, 8 даатгуулагчид 9,208.5 мянган төгрөгийг дутуу олгосон байна. Нийт 28,739.8 мянган төгрөгийн төлбөр зөрчилд Улсын байцаагчийн акт тогтоосон. Мөн ажилгүйдлийн тэтгэмж авч байх хугацаандаа албан журмаар даатгуулагчаар шимтгэл төлж ажилласан 18 даатгуулагчийн ажилд орсон тушаал шийдвэрийг авч зөрчлийг арилгуулах тухай албан бичгийг Тэтгэвэр тэтгэмжийн хэлтэст хүргүүлсэн.	100

3.1.5	Нийгмийн хамгааллын салбарын хяналтын чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн нэр бүхий 351 объектод төлөвлөгөөт шалгалт хийх, мэдээ тайланг нэгтгэх;	Батлагдсан төсвийн хүрээнд	Эрсдэл бүхий аж ахуйн нэгж байгууллагын 80 хүртэл хувийг шалгаж, илэрсэн зөрчлийн 70-аас доошгүй хувийг барагдуулах, -Удирдамжийн хугацаанд мэдээ тайланг нэгтгэж, тайланг Хяналт шалгалтын газарт хүргүүлсэн байна.	2024 онд 15 объектод хяналт шалгалт хийж, 95 зөрчил илрүүлж, 4 албан шаардлага хүргүүлж, гүйцэтгэл 97.8 хувьтай ажилласан.	Их, дунд эрсдэл бүхий аж ахуйн нэгж байгууллагын 80 хүртэл хувийг шалгаж, илэрсэн зөрчлийн 70-аас доошгүй хувийг барагдуулсан байна.	2025 оны эхний хагас жилийн байдлаар их, дунд эрсдэл бүхий аж ахуйн нэгж байгууллагаас 19 байгууллага шалгаснаас 73 зөрчил илэрч 50 хувийг арилгуулсан байна. Дээрх илэрсэн зөрчлийг ангилан үзэхэд: -Ус хангамж, сувагжилт хог хаягдлыг хуримтлуулах, түгээх, зайлуулах, боловсруулах, ариутгах чиглэлээр 2 объект хамрагдаж эрсдэлийн түвшин бага, хууль сахин мөрдөлт 91 хувьтай байна. -Цахилгаан эрчим хүч, дулаан үйлдвэрлэх, түгээх дамжуулах чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй 3 ажил олгогчийн эрсдлийн түвшин бага, хууль сахин мөрдөлтийн түвшин 88.8 байна. -Барилгын угсралт, барилгын материал үйлдвэрлэлийн чиглэлээр урьдчилан сэргийлэх шалгалт төлөвлөгөөт 1, төвөллөгөөт бус 13 объектод хийсэн ба гүйцэтгэлийн шалгалтаар эрсдлийн түвшин тооцно.	100
						НДЕГ-ын даргын 2023 онд баталсан удирдамжийн дагуу 2017-2022 оныг дуусталх хугацааны тус газрын сангийн болон хэлтсийн үйл ажиллагааны зардлын гүйцэтгэлд төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийж гүйцэтгэхэд үндэслэлгүй баримт бичиг бүрдүүлэн шүүхийн шийдвэр гаргуулж тэтгэвэр тогтоолгон авсан 46 иргэнтэй холбоотой 507,578,0 мянган төгрөгийн, нийгмийн даатгалын байцаагчийн алдааны улмаас шалтгаалан 16 иргэнтэй холбоотой 23,707.8 мянган төгрөгийн, нийт	

3.1.6	Нийгмийн даатгалын ерөнхий газраас болон хөндлөнгийн хяналт, шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн барагдуулалтын мэдээ, шалгалтын мөрөөр зохион байгуулж хэрэгжүүлсэн ажлын тайланг улирал тутамд гаргаж Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газарт хүргүүлэх,	-	Хяналт, шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн барагдуулалтын хувь, НДЕГ-т хүргүүлсэн тайлан, мэдээний тоо,	Шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн барагдуулалтын мэдээг НДЕГ-т хүргүүлж ажилласан.	Шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн 70-аас доошгүй хувийг барагдуулж, шалгалтын мөрөөр зохион байгуулж хэрэгжүүлсэн ажлын үр днг тооцож, тайланг улирал тутамд гарган Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газарт хүргүүлж ажилласан байна.	531,286.8 мянган төгрөгийн зөрчил илэрсэн. НДЕГ-ын даргын 2023 оны А/69 дүгээр тушаал “ Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай”-ын дагуу 7 арга хэмжээ 27 ажил үйлчилгээ бүхий төлөвлөгөө хэлтсийн даргаар батлуулан ажиллаж байна. Төлбөр зөрчлийг барагдуулах Улсын байцаагчийн үйлдсэн төлбөр зөрчлийн актаас 351,757.9 мянган төгрөгийг барагдуулан ажиллаж байна. Актын биелэлт 66,2 хувьтай байна. НДЕГ-ын даргын 2024 онд баталсан удирдамжийн дагуу хийгдсэн төлөвлөгөөт бус хяналт шалгалтаар 2 даатгуулагчтай холбоотой 38,970.4 мянган төгрөгийн төлбөр зөрчил илэрч Улсын байцаагчийн акт тогтоосон. Аймгийн Санхүүгийн хяналт,дотоод аудитын албанаас 2023 онд тус газрын 2020-2021 оныг дуусталх хугацааны тус газрын сангийн болон хэлтсийн үйл ажиллагааны зардлын гүйцэтгэлд төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийж гүйцэтгэхэд 3,361.0 мянган төгрөгийн зөрчил илэрч Улсын байцаагчийн акт тогтоож 3,160.0 төгрөгийг барагдуулсан Актын биелэлт 94 хувьтай байна. Дотоодын хяналт шалгалтаар 49,313.6 мянган төгрөгийн төлбөрөөс 12,437.9 мянган төгрөгийг барагдуулан ажиллаж байна. Актын биелэлт 25.2 хувьтай байна.	84.1
-------	--	---	---	--	---	---	------

3.1.7	Дотоодын хяналт, шалгалтын тайланг хагас бүтэн жилээр гаргаж нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлантай тулган баталгаажуулж, заасан хугацаанд Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газарт хүргүүлэх;	-	Дотоодын хяналт, шалгалтын тайланг хугацаанд нь гаргаж хүргүүлэх, төлбөр, зөрлийн 70-аас доошгүй хувийг барагдуулах, үр дүнг тооцож ажиллах,	Дотоодын хяналт, шалгалтын тайлан, мэдээг хагас, бүтэн жилээр гаргуулж, нэгтгэн төлбөр, зөрлийн барагдуулалтад хяналт тавьж ажилласан.	Шалгалтын үр дүнг газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж холбогдох шийдвэр гаргуулан актаар тогтоогдсон төлбөрийн 70-аас доошгүй хувийг барагдуулсан байна.	2025 оны эхний хагас жилийн байдлаар НДЕГ-ын төлөвлөгөөт хяналт шалгалтаар 570,257.2 мянган төгрөгийн зөрчил илэрч Улсын байцаагчийн акт тогтоогдсоноос 351,757.9 мянган төгрөгийг барагдуулан ажиллаж байна. Актын биелэлт 61,6 хувьтай байна. Дотоодын хяналт шалгалтаар 49,313.6 мянган төгрөгийн төлбөрөөс 12,437.9 мянган төгрөгийг барагдуулан ажиллаж байна. Актын биелэлт 25.2 хувьтай байна. НДЕГ газрын ХШГазарт хяналт шалгалтын эхний хагас жилийн тайланд илэрсэн төлбөр зөрчлийг бүрэн тусган тайланг хугацаанд нь хүргүүлсэн.	84.0
Дөрөв. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилт.							
Зорилт 4: “Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг судалж, хэрэгжилтийг хангах, төлөвлөх, тайлагнах, хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийг оновчтой зохион байгуулах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:							
